



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн
2014 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/17/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГЫН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Шинжээч : Д.Цэгмиддорж
Утас: 263813
tsegmiddorjd@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар
Улаанбаатар-15160
Бага тойруу 3
Засгийн газрын IV байр
Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн
горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр
дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн
талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн
нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний талаарх санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2015/17/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүний эрхийн үндэсний комиссын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүний эрхийн үндэсний комиссын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 5-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын шинжээч Д.Цэгмиддорж хэрэгжүүлэв.

Хүний эрхийн үндэсний комиссын 2014 оны санхүүгийн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль батлагдсанаар Хүний эрхийн Үндэсний Комиссын ажиллах эрх зүйн орчин бүрдсэн хууль 6 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд Комисс, түүний гишүүний бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хүний эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Комисст гомдол гаргах, шийдвэрлэх журмыг зохицуулдаг бөгөөд 2001 онд Монгол Улсад Парисын зарчмуудад нийцсэн Хүний эрхийн Үндэсний Байгууллага байгуулагджээ. Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Татварын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль” болон тэдгээртэй нийцүүлэн шинээр гарсан холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Комисс нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга, ил тод байх зарчмыг баримталдаг. Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн Комисс, түүний гишүүний үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

Байгууллагын эрхэм зорилго нь Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих үйлсийг манлайлна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, ажилтнууд

Хараат бус байр суурийг чанд баримталж, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүргээ шинжлэх ухаанчаар, мэргэжлийн түвшинд явуулж,

- Хэлэлцэж, зөвшилцөж, бусдаас тасралтгүй суралцаж,
- Олон ургальч, хариуцлагатай, эвсэг, мэргэшсэн баг, тааламжтай ажиллах орчин бүрдүүлэх замаар эрхэм зорилгодоо хүрнэ.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хүний эрхийн үндэсний комиссын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 8.5 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOLOUS” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналтын талаар

Комисс нь орон тооны нэг нягтлан бодогчтой. Комисс жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган Комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг бөгөөд аливаа арга хэмжээ тус бүрт хөтөлбөр, удирдамж, төсөв батлуулан хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу зарцуулалтыг хийж, хяналт тавьж, тайлагнан ажилладаг байна. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг Комиссын даргын тушаалаар баталдаг бөгөөд тус зөвлөлийн гишүүд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал дээр хяналт тавьж ажиллахаас гадна эд хөрөнгө хариуцагчийн картыг хөтлөн ажиллаж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Комисс жил бүр

төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг ба үүнд санхүүгийн сахилга батыг мөрдөн ажиллах талаар үйл ажиллагаануудыг тусгажээ. Тухайн оноос эхлэн Комиссын даргын 27 тоот тушаалаар Ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг батлан хэрэгжүүлж байгаа, Төрийн албаны тухай хуулиар Ёс зүйн хорооны гишүүдийг сонгон ажиллуулж байгаа зэрэг нь дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

Тус төсөв захирагчид 2014 онд урсгал зардалд 765.4 сая, хөрөнгө оруулалтад 105.0 сая, нийт 870.5 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Хүний эрхийн үндэсний комисс нь хөрөнгө оруулалтаар 105.0 сая төгрөгөөр оффисын тавилга, тоног төхөөрөмж худалдан авахаар батлагдсаны дагуу нээлттэй тендер шалгаруулалт зарлаж 104,9 сая төгрөгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 459.7 сая төгрөгөөр төлөвлөж 457.2 сая төгрөгийн, бараа үйлчилгээний урсгал зардал 226.1 сая төгрөгөөр төлөвлөж 200.0 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2014 оны 12 дугаар сарын 25-нд Комиссын даргын тушаалаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг боловсруулах, цахим хуудсанд байршуулах, нийтэд мэдээлэх, хадгалах” журам баталж дотооддоо мөрдүүлэн ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг нэгдсэн сайт болон Комиссын өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт тавьж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу данс бүрээр хийгдэх хяналтын болон биет сорилыг аудитын арга хандлагын хураангуй маягтаар хяналтын 8, нарийвчилсан 2, нийт 10 сорил, горим гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаар

Тус байгууллагын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусад орлого, цалин, ЭМД, НДШ, ХХОАТ, халаалт, цахилгаан, шатахууны зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Комиссын 2014 оны төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга худалдан авах 105.0 сая төгрөг батлагдсан. Үүнээс нээлттэй тендер шаргарууллалтыг нийтэд зарлаж Саммит Компьютер Технологи ХХК шалгарч, 43.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан байна. Мөн 61.3 сая төгрөгөөр Минторес ХХК-аас албан тасалгааны тавилгын худалдан авалт хийсэн байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад *Хүний эрхийн үндэсний комиссын* Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комиссын зардлаар гадаад томилолтоор явж буй ажиллагсдын онгоцны болон зочид буудлын зардлын зарим холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримт материалыг бүрэн гүйцэд бүрдүүлж байхыг удирдлагын анхааралд хандуулав.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Хүний эрхийн үндэсний комиссын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хүний эрхийн үндэсний комиссын 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар гадаад томилолтоор явж байгаа ажиллагсдын онгоцны болон зочид буудлын зардлын зарим холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүний эрхийн үндэсний комиссын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын газраас хийсэн аудитаар өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

- Санхүү, нягтлан бодох бүртгэл тооцооллын програм хангамжтай болох асуудлыг судлан шийдвэрлэх.

Зөвлөмжийн биелэлт

Санхүүгийн тооцоолох ХХК-ийн ACOLOUS програм хангамжийг худалдан авсан байна.

- Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөх ажиллах

Зөвлөмжийн биелэлт:

Комиссын даргын 2014 оны 36 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.

- 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн залруулах бичилтийг хийх.

Зөвлөмжийн биелэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн програм ашиглан тооцдог болсноор элэгдлийн тооцоолол засагдсан байна.

Зөвлөмж

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж зөрчилгүй санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий Аудитор санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГА Ж.БЯМБАДОРЖ
ТАНАА

2015.04.24 № 799

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	7,489,686.94	8,381,357.97
Кассад байгаа бэлэн мөнгө		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	7,489,686.94	8,381,357.97
<u>АВЛАГА</u>	-	-
Бусад авлага		
<u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u>	-	-
Урьдчилж гарсан зардал		
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	1,051,900.00	1,668,250.00
Хангамжийн материал	1,051,900.00	1,668,250.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,541,586.94	8,541,586.94
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	127,905,676.93	186,600,870.85
<u>Биет хөрөнгө</u>	127,905,676.93	186,600,870.85
Авто- тээврийн хэрэгсэл	62,884,704.00	62,884,704.00
Хуримтлагдсан элэгдэл	(9,432,705.60)	(26,201,960.00)
Машин, тоног төхөөрөмж	92,380,521.00	135,919,221.00
Хуримтлагдсан элэгдэл	(67,234,721.33)	(87,050,801.16)
Тавилга, аж ахуйн эд хогшил	107,134,629.00	168,479,629.00
Хуримтлагдсан элэгдэл	(78,742,511.15)	(88,525,683.00)
Номын фонд	20,915,761.01	21,095,761.01
<u>Биет бүс хөрөнгө</u>	-	-
Програм хангамж	963,000.00	963,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(963,000.00)	(963,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	127,905,676.93	186,600,870.85
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	136,447,263.87	195,142,457.79
<u>Өглөг</u>	-	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг		
<u>Урьдчилж орсон орлого</u>	-	-
Бусад урьдчилж орсон орлого		
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
Урт хугацаат зээл		
<u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
Засгийн газрын капитал	88,356,515.61	88,356,515.61
Дахин үнэлгээний нөөц	8,900,164.00	8,900,164.00
Өмнөх үеийн үр дүн	(30,399,364.85)	39,190,584.26
Тайлант үеийн үр дүн	69,589,949.11	60,203,214.95
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>	136,447,263.87	196,650,478.82
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>	136,447,263.87	196,650,478.82

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	546,635,950.00	870,340,100.00
Урсгал	526,751,400.00	765,456,400.00
Хөрөнгийн	19,884,550.00	104,883,700.00
Нийгмийн даатгалын сангаас		
Бусад тусгай зориулалтын сангаас		
Урсгал тусламж /төсөл арга хэмжээ/	53,377,446.54	39,873,198.20
Хандив, тусламжийн орлого	67,823,815.27	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,662.42	472,121.45
Ангилалдаагүй орлого /Арилжааны банк дахь дансны/	1,662.42	472,121.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667,838,874.23	910,685,419.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	342,990,510.06	507,178,020.34
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	309,625,610.78	457,172,181.34
Үндсэн цалин	292,084,898.78	432,416,970.34
Унаа болон бусад нөхөн олговор	17,540,712.00	24,755,211.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	33,364,899.28	50,005,839.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	27,299,160.59	40,004,671.00
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	21,232,680.46	30,861,228.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,426,592.05	3,657,377.00
ҮОМШ өвчний даатгал	3,033,240.07	4,571,722.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	606,648.01	914,344.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,065,738.69	10,001,168.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	196,904,492.09	236,531,165.55
Бусад бараа үйлчилгээний зардал	196,904,492.09	236,531,165.55
Бичиг хэргийн материал	7,443,150.60	12,794,130.00
Тээвэр, шатахууны зардал	33,736,140.00	31,158,047.00
Шуудан холбооны зардал	11,257,950.90	22,459,514.85
Дотоод томилолтын зардал	23,059,425.00	13,034,674.20
Гадаад томилолтын зардал	22,164,342.42	13,784,810.00
Ном, хэвлэлийн зардал	17,205,000.00	26,716,300.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	28,957,209.60	56,668,860.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	650,000.00	1,173,400.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	23,377,370.47	8,127,073.42
Тээврийн хэрэгслийн татвар		80,000.00
Урсгал засварын зардал	500,000.00	-
Гадаадын зочны зардал	2,188,300.00	4,165,850.00
Элэгдлийн зардал	26,365,603.10	46,368,506.08
Тусламж, шилжүүлэг	14,538,982.97	45,997,470.81
Олон улсын байгууллагын гишүүний татвар	11,876,860.00	15,797,271.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,662,122.97	30,200,199.81
Засгийн газрын нөөц хөрөнгө		

Нийгмийн хамгааллын зардал	28,077,626.00	19,908,719.00
Нэг удаагийн тэтгэмж	13,690,333.00	
Нэг удаагийн буцалтгүй тусламж	850,000.00	19,908,719.00
Шагнал, урамшуулал	13,537,293.00	
Бусад зардал	15,737,314.00	40,866,829.00
Байрны түрээсийн зардал	15,737,314.00	40,866,829.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	598,248,925.12	850,482,204.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	69,589,949.11	60,203,214.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		-
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Хөрөнгө худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	69,589,949.11	60,203,214.95

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	600,013,396.54	910,213,298.20
Олон улсын байгууллагын тусламж	53,377,446.54	39,873,198.20
Урсгал тусламж	53,377,446.54	39,873,198.20
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	546,635,950.00	870,340,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	546,635,950.00	870,340,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,751,400.00	765,456,400.00
Хөрөнгийн санхүүжилт	19,884,550.00	104,883,700.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,662.42	472,121.45
Ангилалдаагүй орлого /Арилжааны банк дахь дансны үлдэгдэл/	1,662.42	472,121.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	600,015,058.96	910,685,419.65
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	342,990,510.06	507,178,020.34
Үндсэн болон нэмэгдэл цалин	309,625,610.78	457,172,181.34
Үндсэн цалин	292,084,898.78	432,416,970.34
Унаа болон бусад нөхөн олговор	17,540,712.00	24,755,211.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	33,364,899.28	50,005,839.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	27,299,160.59	40,004,671.00
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	21,232,680.46	30,861,228.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,426,592.05	3,657,377.00
ҮОМШ өвчний даатгал	3,033,240.07	4,571,722.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	606,648.01	914,344.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,065,738.69	10,001,168.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	186,890,002.99	231,645,838.47
Бусад бараа үйлчилгээний зардал	186,890,002.99	231,645,838.47
Бичиг хэргийн материал	8,056,950.60	13,410,480.00
Тээвэр, шатахууны зардал	33,736,140.00	31,158,047.00
Шуудан холбооны зардал	11,257,950.90	22,459,514.85
Дотоод томилолтын зардал	23,059,425.00	13,034,674.20
Гадаад томилолтын зардал	24,438,182.42	13,784,810.00
Ном, хэвлэлийн зардал	19,002,820.00	26,716,300.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	24,885,549.60	56,668,860.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	650,000.00	1,173,400.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	23,377,370.47	8,127,073.42
Тээврийн хэрэгслийн татвар		80,000.00
Урсгал засварын зардал	500,000.00	-
Гадаадын зочны зардал	2,188,300.00	4,165,850.00
Байрны түрээсийн зардал	15,737,314.00	40,866,829.00
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	14,538,982.97	45,997,470.81
Олон улсын байгууллагуудад	11,876,860.00	15,797,271.00
Олон улсын гишүүний татвар, хандив	11,876,860.00	15,797,271.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,662,122.97	30,200,199.81
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	28,077,626.00	19,908,719.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	28,077,626.00	19,908,719.00
Нэг удаагийн тэтгэмж	13,690,333.00	
Нэг удаагийн буцалтгүй тусламж	850,000.00	19,908,719.00
Шагнал урамшил	13,537,293.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	572,497,122.02	804,730,048.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	27,517,936.94	105,955,371.03

Хөрөнгийн орлого	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,028,250.00	105,063,700.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,028,250.00	105,063,700.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,028,250.00)	(105,063,700.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)	7,489,686.94	891,671.03
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,489,686.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,489,686.94	8,381,357.97

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	(30,399,364.85)	66,857,314.76
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	(30,399,364.85)	66,857,314.76
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
Үндсэн хөрөнгийн өсөлт/ +/, бууралт /-/				-
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	39,190,584.26	136,447,263.87
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	39,190,584.26	136,447,263.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
Үндсэн хөрөнгийн өсөлт			60,203,214.95	60,203,214.95
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	88,356,515.61	8,900,164.00	99,393,799.21	196,650,478.82

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	935,211,700.00	870,812,221.00	64,399,479.00	93.11%
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	935,211,700.00	870,812,221.00	64,399,479.00	93.11%
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	830,328,000.00	765,748,521.00	64,579,479.00	92.22%
Бараа ажил үйлчилгээний зардал	830,328,000.00	765,748,521.00	64,579,479.00	92.22%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,477,000.00	457,172,181.34	8,304,818.66	98.22%
Үндсэн цалин	433,726,200.00	432,416,970.34	1,309,229.66	99.70%
Унаа, болон бусад нөхөн олговор	31,750,800.00	24,755,211.00	6,995,589.00	77.97%
Нийгмийн хамгааллын шимтгэл	51,418,800.00	50,005,839.00	1,412,961.00	97.25%
Тэтгэврийн даатгал	32,721,200.00	30,861,228.00	1,859,972.00	94.32%
Тэтгэмжийн даатгал	3,739,400.00	3,657,377.00	82,023.00	97.81%
ҮОМШ өвчний даатгал	4,674,600.00	4,571,722.00	102,878.00	97.80%
Ажилгүйдлын даатгал	934,800.00	914,344.00	20,456.00	97.81%
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	9,348,800.00	10,001,168.00	(652,368.00)	106.98%
Бараа, үйлчилгээний бусад зардал	313,432,200.00	258,570,500.66	54,861,699.34	82.50%
Бичиг хэрэг	30,264,000.00	13,410,480.00	16,853,520.00	44.31%
Тээвэр (шатахуун)	26,124,900.00	27,759,641.00	(1,634,741.00)	106.26%
Шуудан холбоо	35,245,500.00	22,459,514.85	12,785,985.15	63.72%
Дотоод албан томилолт	15,434,000.00	3,048,000.00	12,386,000.00	19.75%
Гадаад томилолт арга хэмжээ	14,214,900.00	13,784,810.00	430,090.00	96.97%
Урсгал засвар	424,000.00	-	424,000.00	0.00%
Төлбөр хураамж бусад зардал	11,504,400.00	5,549,619.00	5,954,781.00	48.24%
Ном хэвлэл авах	26,666,400.00	23,916,300.00	2,750,100.00	89.69%
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\	2,650,000.00	1,173,400.00	1,476,600.00	44.28%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх	55,200,000.00	43,613,000.00	11,587,000.00	79.01%
Гадаад зочны зардал	8,820,000.00	4,165,850.00	4,654,150.00	47.23%
Олон улсын гишүүний татвар	12,200,000.00	15,797,271.00	(3,597,271.00)	129.49%
Тээврийн хэрэгслийн даатгал	900,000.00	-	900,000.00	0.00%
Байрны түрээсийн зардал	53,865,300.00	40,866,829.00	12,998,471.00	75.87%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	19,838,800.00	12,745,586.00	7,093,214.00	64.25%
Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00	-	100.00%
Төвлөрүүлэх шилжүүлэг		30,200,199.81	(30,200,199.81)	
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	104,883,700.00	105,063,700.00	(180,000.00)	100.17%
1. Дотоод хөрөнгө оруулалт			-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих их засвар			-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	104,883,700.00	104,883,700.00	-	100.00%
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт			-	
Бусад (Хөрөнгө оруулалт)		180,000.00	(180,000.00)	
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ			-	
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	935,211,700.00	870,812,221.45	64,399,478.55	93.11%
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих			-	
Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих			-	
Татварын бус бусад орлого		472,121.45	(472,121.45)	
Төсвөөс санхүүжих	935,211,700.00	870,340,100.00	64,871,600.00	93.06%

Урсгал санхүүжилт	830,328,000.00	765,456,400.00	64,871,600.00	92.19%
Хөрөнгө оруулалт	104,883,700.00	104,883,700.00	-	100.00%
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	0.45	-	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		1,662.42	-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /Нэмэлт санхүүжилтийн/		8,381,357.52	-	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		-1662.42		
Байгууллагын тоо	1	1	-	
Ажиллагсад бүгд	49	48	1	97.96%
Удирдах ажилтан	4	4	-	100.00%
Гүйцэтгэх ажилтан	41	40	1	97.56%
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.00%
Гэрээт ажилтан	0	0	-	